



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/125/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Сайншанд хот 2020 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 70523020 Цахим хаяг: enkhtsetseg.e@audit.gov.mn Аудитор: О.Нарангарав Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1.	Оршил	5
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1.	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал.....	12
3.1	Зардлын данстай холбоотой.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	19
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6	Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	202

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.МАРТ ТАНАА
2020.01.30 № 16/40 танай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
<p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p>	
019020001	

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Март-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.27-оос 2020.01.28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.28-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2020.01.23-ны өдрийн 7/24 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь “Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ татварын алба, татвар төлөгч шударгаар биелүүлэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Шинэтгэлийн жил” болгон зарлаж, Төрийн албаны тухай хууль тогтоомж, дагалдан гарах дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, Татварын багц хууль, тогтоомж, дагалдан гарах дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллах

Дорноговь аймгийн Татварын хэлтэс үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд
- Сангийн сайдын төсвийн үйл ажиллагаатай холбоотой тушаалууд
- Гаалийн ерөнхий газрын холбогдох хууль тогтоомж

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Татварын хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Emerald” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 2 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 1 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт хөрөнгө болон цэвэр хөрөнгөөс материаллаг байдлын түвшинг тогтооход бага гарч байгаа тул үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээс материаллаг байдлын түвшинг тогтоов.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны нийт зардал 766,567.1 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 7,665.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 1 хувиар тооцсон нь төлөвлөлтийн үе шатанд тооцсон хувиар тооцох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 1 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	Тоо	Дүн	(Мянган төгрөгөөр)
				Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	586.9	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	144.0	
3	Албан шаардлага өгсөн	2	2,118.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	4	2,848.9	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2020 оны 7/24 тоот албан бичгээр ирүүлсэн санхүүгийн тайлангийн уялдааг давтан шалгах явцад НББ-ийн бичилтийг данс андууран бүртгэсэнтэй холбоотой 33,458.2 мянган төгрөгийн 3 алдаа илэрлээ.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4 дэх заалт, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаал зэргийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад залруулан бүртгэсэн.

2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Ажилчдад олгосон түлээ нүүрсний хөнгөлөлтөөс НДШ суутгаагүй олгож, нийгмийн даатгалын тооцооллыг хийгээгүй орхигдуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Аймгийн Засаг даргын 2019 оны 1/1165 тоот албан бичгийг үндэслэн байгууллагын даргад нэг сарын үндсэн цалинтай тэнцэх урамшуулал тооцож олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

2.8.1.4 Зардлын данстай холбоотой асуудал

Байгууллагын даргын 2016 оны А/39 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-д тусгагдаагүй тэтгэмжийг албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Аудитаар албан шаардлага тогтоохоор шийдвэрлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 742,758.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 741,956.6 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бараа материалын зарим зардал зарцуулагдаагүй хэмнэлттэй үлдсэн нь шалтгаалжээ.

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь 2019 онд улсын төсвөөс 742.8 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 632.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн

орлого 1.0 сая төгрөг буюу нийт 744,390.2 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.

Албан хаагчдын цалин, НДШ-ийн зардал 640.3 сая төгрөг нь нийт зардлын 86.0 хувь, бараа үйлчилгээний урсгал зардал 102.7 сая төгрөг нь нийт зардлын 13.8 хувь, Төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 1.4 сая төгрөг нь нийт зардлын 0.2 хувийг тус тус эзэлж байна. Тайлант онд үйл ажиллагааны орлогоос орсон 632.2 мянган төгрөг, оны эцэст зарцуулагдаагүй төсвийн үлдэгдэл 801.4 мянган төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн байдлын тайлангаар жилийн эцэст авлага, ер төлбөргүй, бараа материалын үлдэгдэл өмнө оныхоос 8.2 сая төгрөгөөр, цэвэр үндсэн хөрөнгийн үлдэгдэл 51,026.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл өсөхөд Татварын ерөнхий газраас үнэ төлбөргүй олгосон албан хаагчдын дүрэмт хувцас болон бусад материалын олголт нөлөөлсөн байна.

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь 2019 онд Татварын ерөнхий газрын шийдвэрээр 66.9 сая төгрөгийн суудлын автомашиныг балансаас балансад шилжүүлэн бүртгэн авч, ТӨБЗГ-ын 2019 оны А-2/1155 тоот албан бичгээр 17.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хассан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Татварын хэлтэс нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой

3.1.1 Илрүүлэлт:

Цалингийн зардлаас 586.9 мянган төгрөгийг ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна МУ-ын Төсвийн тухай хуулийн 16.5.5, дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн зардал буруу тайлагнагдах, төсөв буруу батлагдах эрсдэлтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулан тайлагнаж байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Өгч буй зөвлөмжид санал байхгүй гэсэн хариу тайлбарыг баталгаажуулан ирүүлсэн байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 06-р сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,476,287.00	22,726,679.06
35	БАРАА МАТЕРИАЛ	14,476,287.00	22,726,679.06
354	Хангамжийн материал	14,476,287.00	22,726,679.06
35410	Бичиг хэргийн материал	453,500.00	417,900.00
35420	Аж ахуйн материал	12,640,040.00	21,527,405.00
35440	Түлш, шатах тослох материал	670,046.00	250,356.00
35470	Бусад хангамжийн материал	712,701.00	531,018.06
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	195,681,118.87	246,707,304.51
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	195,681,118.87	246,707,304.51
392	Биет хөрөнгө	195,131,118.87	246,340,468.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	141,654,661.00	141,654,661.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3,181,391.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,300,000.00	134,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-30,130,670.38	-40,448,377.46
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	96,711,895.75	80,802,427.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	-93,583,467.11	-78,924,701.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,187,617.00	23,171,226.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,656,034.15	-18,384,546.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,764,800.00	11,764,800.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,117,683.24	-4,313,629.84
393	Биет бус хөрөнгө	550,000.00	366,835.70
39301	Программ хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	183,164.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	210,157,405.87	269,433,983.57
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	210,157,405.87	269,433,983.57
51	Засгийн газрын хувь оролцоо	210,157,405.87	269,433,983.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	254,724,803.55	254,724,803.55
51101	Өмч: - төрийн	254,724,803.55	254,724,803.55
512	Хуримтлагдсан үр дүн	-136,249,454.77	-76,972,877.07
51210	Өмнөх үеийн үр дүн	-132,463,408.83	-136,249,454.77
51220	Тайлант үеийн үр дүн	-3,786,045.94	59,276,577.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	91,682,057.09	91,682,057.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	210,157,405.87	269,433,983.57

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	643,064,002.14	826,026,889.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,748,402.14	82,268,889.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,748,402.14	82,268,889.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,042,871.00	632,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,042,871.00	632,200.00
120010	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,705,531.14	81,636,689.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,315,600.00	743,758,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	629,315,600.00	742,758,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,315,600.00	742,758,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	1,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	646,850,048.08	766,750,311.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	646,850,048.08	766,750,311.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	639,834,112.08	757,266,748.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,834,082.00	569,062,827.00
210101	Үндсэн цалин	437,113,201.00	507,891,227.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,310,500.00	13,043,000.00
210104	Урамшуулал	39,410,381.00	48,128,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,331,739.00	71,229,558.00
210201	Тэтгэврийн даатгал	39,069,071.00	48,919,673.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,981,811.00	5,749,695.00
210203	ҮОМШ өвчний даатгал	3,939,353.00	4,551,125.00
210204	Ажилгүйдлийн даатгал	940,138.00	1,132,034.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,401,366.00	10,877,031.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,706,972.00	16,739,770.00
210301	Гэрэл цахилгаан	2,368,241.00	2,648,305.00
210302	Түлш, халаалт	10,819,787.00	12,937,015.00
210303	Цэвэр, бохир ус	518,944.00	554,450.00
210304	Байрны түрээс	0.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,753,999.00	23,574,696.00
210401	Бичиг хэрэг	6,690,134.00	7,579,012.00
210402	Тээвэр шатахуун	4,460,877.00	6,222,490.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,542,948.00	8,332,004.00
210404	Ном, хэвлэл	36,700.00	122,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	783,340.00	1,078,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,988,420.00	7,795,050.00
210604	Урсгал засвар	2,988,420.00	7,795,050.00
2107	Томилолт, зочны зардал	5,771,200.00	4,631,200.00
210702	Дотоод албан томилолт	5,771,200.00	4,631,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	36,944,642.97	39,707,832.94

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,488,000.00	29,956,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,294,450.00	1,340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,580.00	68,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	22,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,859,612.97	8,141,096.94
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,503,057.11	24,525,814.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,051,000.00	8,652,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	13,452,057.11	15,873,814.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,015,936.00	9,483,563.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,492,000.00	8,050,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,492,000.00	6,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,523,936.00	801,363.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,523,936.00	801,363.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	632,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	632,200.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,786,045.94	59,276,577.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,786,045.94	59,276,577.70

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	636,968,400.00	744,390,200.00
110003	Хөрөнгийн орлого		
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,652,800.00	632,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,652,800.00	632,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,652,800.00	632,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,652,800.00	632,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	635,315,600.00	743,758,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	629,315,600.00	742,758,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	629,315,600.00	742,758,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	1,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	636,968,400.00	744,390,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	636,968,400.00	744,390,200.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,952,464.00	734,906,637.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	487,883,115.00	569,649,740.00
210101	Үндсэн цалин	342,892,341.00	404,707,184.00
210102	Нэмэгдэл	91,869,576.00	103,770,956.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	13,310,500.00	13,043,000.00
210104	Урамшуулал	39,810,698.00	48,128,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,892,635.00	70,642,655.00
210201	Тэтгэврийн даатгал	40,406,925.00	48,249,822.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,044,514.00	5,745,276.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,895,025.00	4,557,817.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,695,523.00	6,809,222.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,850,648.00	5,280,518.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,706,972.00	16,739,770.00
210301	Гэрэл, цахилгаан	2,368,241.00	2,648,305.00
210302	Түлш, халаалт	10,819,787.00	12,937,015.00
210303	Цэвэр, бохир ус	518,944.00	554,450.00
210304	Байрны түрээс	0.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,524,092.00	25,229,486.00
210401	Бичиг хэрэг	6,942,034.00	7,957,412.00
210402	Тээвэр, шатахуун	5,001,250.00	5,802,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,542,948.00	8,332,004.00
210404	Ном, хэвлэл	51,700.00	150,050.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,746,160.00	2,747,220.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,488,420.00	7,795,050.00

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	3,828,420.00	7,795,050.00
2107	Томилолт, зочны зардал	5,771,200.00	4,631,200.00
210702	Дотоод албан томилолт	5,771,200.00	4,631,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,635,030.00	31,566,736.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,038,000.00	29,956,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,294,450.00	1,340,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	68,580.00	68,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	54,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,051,000.00	8,652,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,051,000.00	8,652,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,015,936.00	9,483,563.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,492,000.00	8,050,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,492,000.00	6,550,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,523,936.00	801,363.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,523,936.00	801,363.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	632,200.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	632,200.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	254,724,803.55	136,861,906.94	-132,463,408.83	259,123,301.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,724,803.55	136,861,906.94	-132,463,408.83	259,123,301.66
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-45,179,849.85	0.00	-45,179,849.85
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,786,045.94	-3,786,045.94
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	254,724,803.55	91,682,057.09	-136,249,454.77	210,157,405.87
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	254,724,803.55	91,682,057.09	-136,249,454.77	210,157,405.87
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,724,803.55	91,682,057.09	-136,249,454.77	210,157,405.87
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	59,276,577.70	59,276,577.70
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	254,724,803.55	91,682,057.09	-76,972,877.07	269,433,983.57

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	742,758,000.00	741,956,637.00	801,363.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	742,758,000.00	741,956,637.00	801,363.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	735,683,000.00	734,906,637.00	776,363.00
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	570,007,000.00	569,649,740.00	357,260.00
210101	Үндсэн цалин	377,045,300.00	404,707,184.00	(27,661,884.00)
210102	Нэмэгдэл цалин	101,566,300.00	103,770,956.00	(2,204,656.00)
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	18,185,000.00	13,043,000.00	5,142,000.00
210104	Урамшуулал	73,210,400.00	48,128,600.00	25,081,800.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,000,900.00	70,642,655.00	358,245.00
210201	Тэтгэврийн даатгал	48,793,000.00	48,249,822.00	543,178.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,552,000.00	5,745,276.00	(193,276.00)
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,441,600.00	4,557,817.00	(116,217.00)
210204	Ажилгүйдлийн даатгал	1,110,400.00	6,809,222.00	(5,698,822.00)
210205	Эрүүл мэндийн даатгал	11,103,900.00	5,280,518.00	5,823,382.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,739,800.00	16,739,770.00	30.00
210301	Гэрэл, цахилгаан	2,800,000.00	2,648,305.00	151,695.00
210302	Түлш, халаалт	12,946,100.00	12,937,015.00	9,085.00
210303	Цэвэр, бохир ус	393,700.00	554,450.00	(160,750.00)
210304	Байрны түрээс	600,000.00	600,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	25,233,300.00	25,229,486.00	3,814.00
210401	Бичиг хэрэг	6,500,000.00	7,957,412.00	(1,457,412.00)
210402	Тээвэр, шатахуун	6,300,000.00	5,802,800.00	497,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,790,000.00	8,332,004.00	1,457,996.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	150,050.00	349,950.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	343,300.00	240,000.00	103,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,747,220.00	(947,220.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,800,000.00	7,795,050.00	4,950.00
210604	Урсгал засвар	7,800,000.00	7,795,050.00	4,950.00
2107	Томилолт, зочны зардал	4,650,000.00	4,631,200.00	18,800.00
210702	Дотоод албан томилолт	4,650,000.00	4,631,200.00	18,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,600,000.00	31,566,736.00	33,264.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,956,000.00	29,956,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	180,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,340,000.00	1,340,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,000.00	68,736.00	264.00

Дорноговь аймгийн Татварын хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	22,000.00	33,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,652,000.00	8,652,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	8,652,000.00	8,652,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,075,000.00	7,050,000.00	25,000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,075,000.00	7,050,000.00	25,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,575,000.00	5,550,000.00	25,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,500,000.00	1,500,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	742,758,000.00	742,758,000.00	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	742,758,000.00	742,758,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	742,758,000.00	742,758,000.00	-

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	1,000,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6,000,000.00	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	1,000,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	-1,000,000.00